



I-VI/2022

Тархаасан: 2022 оны 7 дугаар сарын 18




Улсын хэмжээнд 2022 оны эхний хагас жилд 218.1 мянган мал хорогдсон байна

Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 30.8 сая хээлтэгч малын 25.0 сая (81.3%) нь 2022 оны эхний хагас жилд төллөсөн байна. Эм хонины 84.6 хувь, эм ямааны 81.5 хувь, үнээний 70.0 хувь, гүүний 67.0 хувь, ингэний 41.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 98.1 хувь буюу 24.6 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 4.7 (23.8%) саяар өссөн байна.

ЗУРАГ 1. ТӨЛ БОЙЖИЛТ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, төрлөөр, хувиар



Том малын зүй бус хорогдол 2022 оны эхний хагас жилд улсын хэмжээнд 218.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 2.2 (90.9%) саяар буурсан байна.

Харин 2022 оны 6 дугаар сард 29.7 мянган мал хорогдсон нь эхний хагас жилийн хорогдсон малын 13.6 хувийг эзэлж байгаа бол 5 дугаар сард хорогдсон малаас 29.3 (49.7%) мянгаар буурсан байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 94.0 мянга, ямаа 90.4 мянга, үхэр 20.4 мянга, адуу 13.0 мянга, тэмээ 303-аар хорогдсон байна. Нийт хорогдсон малын 43.1 хувийг хонь, 41.4 хувийг ямаа эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилд

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2022 I-VI
	мянган толгой				хувь			
Дүн	735.1	1 308.8	2 387.3	218.1	1.11	1.84	3.56	0.32
Адуу	38.2	67.5	87.1	13.0	0.97	1.60	2.13	0.30
Үхэр	49.1	94.7	144.8	20.4	1.12	1.99	3.06	0.41
Тэмээ	1.0	0.7	15.0	0.3	0.21	0.15	3.17	0.07
Хонь	308.5	658.0	843.0	94.0	1.01	2.04	2.81	0.30
Ямаа	338.3	488.0	1 297.5	90.4	1.25	1.67	4.68	0.34

Энэ оны эхний хагас жилд Хэнтий аймагт 42.3 (19.4%) мянга, Архангай аймагт 37.4 (17.1%) мянга, Хөвсгөл аймагт 21.9 (10.0%) мянга, Увс аймагт 17.6 (8.1%) мянга, Төв аймагт 15.8 (7.2%) мянган мал хорогдсон нь нийт хорогдлын 61.8 хувийг эзэлж байна.


ЗУРАГ 1. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, аймаг, нийслэлээр, мянган толгой



Улсын хэмжээнд 2021 оны эцэст тоологдсон 30.8 сая эх малын 58.2 мянга (0.2%) нь энэ оны эхний хагас жилд хорогдсон байна. Хэнтий, Архангай, Төв, Хөвсгөл, Увс аймагт хээлтэгч мал 4.2-15.8 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 62.4 хувийг эзэлж байна. Харин хээлтүүлэгч малаас ухна 1.6 мянга, хуц 1.6 мянга, бух 568, азарга 287, буур 5 буюу нийт 4.0 мянган мал хорогдсон байна.

Улсын хэмжээнд 2022 оны эхний хагас жилд 13.2 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.2 (8.4%) мянгаар буурсан байна.

ЗУРАГ 3. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 90.2 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 3.7 хувь нь аюулт үзэгдлээр, 6.1 хувь нь өвчнөөр тус тус хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.



Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Эх үүсвэр:

ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 8 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Л.Шинэтуяа
Утас: (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212